

## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хараагүй хүмүүсийн хөдөлмөр, сургалт хөгжлийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** СНАГ-2025/237/НА-СТА-ТШЗ

|   |   |
|---|---|
| Цахим хуудас:<br><a href="#">www.audit.mn</a><br>Улаанбаатар хот<br>2025 он | Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,<br>тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг<br>Утас: 261663 Цахим хаяг: <a href="#">naranchimegts@audit.gov.mn</a><br>Аудитын менежер: А.Цогбаяр<br>Утас: 261815 Цахим хаяг: <a href="#">tsogbayara@audit.gov.mn</a><br>Аудитор: Д.Номингуа<br>Утас: 261815 Цахим хаяг: <a href="#">nominguad@audit.gov.mn</a><br>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Эс Жи Эм Ди Аудит<br>ХХК-ийн захирал: Д.Эхбаяр<br>Утас: 99116948 Цахим хаяг: <a href="#">ekhbayar@sgmd-audit.mn</a> |
|---|---|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.24 № 07/643  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ХАРААГҮЙ ХҮМҮҮСИЙН  
ХӨДӨЛМӨР, СУРГАЛТ ХӨГЖЛИЙН  
ТӨВИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
З.ЛХАГВАСҮРЭН ТАНАА

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хараагүй хүмүүсийн хөдөлмөр, сургалт хөгжлийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тайлант болон өмнөх онуудад үүссэн нийт 64,243.6 мянган төгрөгийн авлагыг аж ахуйн нэгж, байгууллагатай тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшнээс дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь заалтуудтай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын "эрх ба үүрэг", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих арга хэмжээнд 717,550.0 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлсний үр дүнд харааны бэрхшээлтэй иргэдийг тохирох ажлын байраар хангаж, хөдөлмөр эрхлүүлж, нийгмийн харилцаанд оролцох бүх талын тусламж, дэмжлэгийн чанар, хүртээмж дээшилж, цалин хөлс

Z:\Yawsan\_Bichig\2025\0224 SNAG-9 Docx

1595070092

нэмэгдэж, ажиллах орчин нөхцөл сайжирч, байгууллагын санхүү, хөрөнгө оруулалтын чадавх нэмэгдсэн байна.

#### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөөг 33,759.3 мянган төгрөг буюу 16.1 хувиар давуулан биелүүлсэн байна. Тус төвийн ажилчдыг тохирох ажлын байраар хангаж, нийгмийн оролцоо, хөгжлийг дэмжих зорилгоор 717,544.5 мянган төгрөгийн татаас санхүүжилтийг Засгийн газраас олгосон байна.

#### **Бусад асуудал**

Харааны бэрхшээлтэй 11 иргэнд ажлын байрны сургалт зохион байгуулж, 4 иргэнийг ажлын байраар хангасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэл гарах хэрэгтэй гэдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *Б. Наранчимэг* Ц.НАРАНЧИМЭГ



## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Дансны код  | Балансын үзүүлэлт   | Эхний үлдэгдэл          | Эцсийн үлдэгдэл         |
|-------------|---|-------------------------|-------------------------|
| <b>1</b>    | <b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>  | <b>355,954,586.51</b>   | <b>180,741,219.09</b>   |
| <b>33</b>   | <b>АВЛАГА</b>   | <b>199,480,330.00</b>   | <b>64,243,600.00</b>    |
| 33300       | Татаас, санхүүжилтийн авлага  | 152,965,630.00          | 17,728,900.00           |
| <b>336</b>  | <b>Зээлийн авлага</b>   | <b>46,514,700.00</b>    | <b>46,514,700.00</b>    |
| <b>3361</b> | <b>Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага</b>                     | <b>46,514,700.00</b>    | <b>46,514,700.00</b>    |
| 33612       | Хувь хүмүүст олгосон зээл   | 46,514,700.00           | 46,514,700.00           |
| <b>35</b>   | <b>БАРАА МАТЕРИАЛ</b>   | <b>156,474,256.51</b>   | <b>116,597,619.09</b>   |
| <b>351</b>  | <b>Түүхий эд материал</b>   | <b>27,019,900.00</b>    | <b>14,688,920.00</b>    |
| 35110       | Тусгай зориулалттай материал  | 27,019,900.00           | 14,688,920.00           |
| 35200       | Дуусаагүй үйлдвэрлэл  | 58,365,735.51           | 23,581,808.09           |
| 35300       | Бэлэн бүтээгдэхүүн  | 41,806,297.00           | 33,371,504.00           |
| <b>354</b>  | <b>Хангамжийн материал</b>  | <b>29,282,324.00</b>    | <b>44,855,387.00</b>    |
| 35420       | Аж ахуйн материал   | 3,600,654.00            | 6,673,010.00            |
| 35470       | Бусад хангамжийн материал   | 25,681,670.00           | 38,182,377.00           |
| <b>2</b>    | <b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>                                    | <b>6,261,498,584.47</b> | <b>6,206,920,024.00</b> |
| <b>39</b>   | <b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>   | <b>6,261,498,584.47</b> | <b>6,206,920,024.00</b> |
| <b>392</b>  | <b>Биет хөрөнгө</b>   | <b>5,884,002,057.92</b> | <b>5,829,419,830.85</b> |
| 39201       | Барилга, байгууламж, орон сууц  | 6,797,348,888.91        | 6,862,825,692.91        |
| 39202       | Хуримтлагдсан элэгдэл   | (987,540,542.13)        | (1,197,653,243.94)      |
| 39203       | Авто тээврийн хэрэгсэл  | -                       | 46,000,000.00           |
| 39204       | Хуримтлагдсан элэгдэл   | -                       | (4,472,222.22)          |
| 39205       | Машин тоног төхөөрөмж (компьютер)                                     | 204,783,301.00          | 169,395,815.00          |
| 39206       | Хуримтлагдсан элэгдэл   | (133,621,534.30)        | (52,079,615.93)         |
| 39207       | Тавилга, аж ахуйн эд хогшил   | 12,289,809.00           | 7,992,175.00            |
| 39208       | Хуримтлагдсан элэгдэл   | (9,257,864.56)          | (2,588,769.96)          |
| <b>393</b>  | <b>Биет бус хөрөнгө</b>   | <b>377,496,526.55</b>   | <b>377,500,193.15</b>   |
| 39301       | Программ хангамж  | 1,650,000.00            | 1,111,000.00            |
| 39302       | Хуримтлагдсан элэгдэл   | (1,283,333.45)          | (740,666.85)            |
| 39303       | Бусад биет бус хөрөнгө  | 377,129,860.00          | 377,129,860.00          |
| <b>3</b>    | <b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>                                    | <b>6,617,453,170.98</b> | <b>6,387,661,243.09</b> |
| <b>5</b>    | <b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>                                       | <b>6,617,453,170.98</b> | <b>6,387,661,243.09</b> |
| <b>51</b>   | <b>Засгийн газрын хувь оролцоо</b>                                    | <b>6,617,453,170.98</b> | <b>6,387,661,243.09</b> |
| 511         | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 5,959,596,819.84        | 5,959,596,819.84        |

|            |  |                         |                           |
|------------|--|-------------------------|---------------------------|
| 51101      | Өмч: - төрийн                                      | 735,641,614.84          | 735,641,614.84            |
| 51106      | Эздийн өмчийн бусад хэсэг                          | 5,223,955,205.00        | 5,223,955,205.00          |
| <b>512</b> | <b>Хуримтлагдсан үр дүн</b>                        | <b>(979,338,439.06)</b> | <b>(1,209,130,366.95)</b> |
| 51210      | Өмнөх үеийн үр дүн                                 | (943,785,037.38)        | (979,338,439.06)          |
| 51220      | Тайлант үеийн үр дүн                               | (35,553,401.68)         | (229,791,927.89)          |
| 51300      | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү                   | 1,637,194,790.20        | 1,637,194,790.20          |
| <b>6</b>   | <b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b> | <b>6,617,453,170.98</b> | <b>6,387,661,243.09</b>   |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Дансны код  | Үзүүлэлт   | Өмнөх он                | Тайлант он              |
|-------------|--|-------------------------|-------------------------|
| <b>1</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>                                       | <b>1,482,004,578.00</b> | <b>1,779,989,288.00</b> |
| <b>12</b>   | <b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>   | <b>121,507,620.00</b>   | <b>359,841,488.00</b>   |
| <b>120</b>  | <b>Нийтлэг татварын бус орлого</b>   | 121,507,620.00          | 346,446,688.00          |
| 120004      | Төсөв байгууллагын өөрийн орлого   | 121,507,620.00          | 346,446,688.00          |
| 1200041     | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих                                    | 71,343,120.00           | 243,759,350.00          |
| 1200045     | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого  | 50,164,500.00           | 102,687,338.00          |
| <b>122</b>  | <b>Тусламжийн орлого</b>   | -                       | <b>13,394,800.00</b>    |
| 122001      | Хандив тусламж /дотоод/  | -                       | 13,394,800.00           |
| <b>13</b>   | <b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>   | <b>1,360,496,958.00</b> | <b>1,420,147,800.00</b> |
| <b>1310</b> | <b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>   | <b>1,207,531,328.00</b> | <b>1,402,418,900.00</b> |
| 131001      | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт  | 1,207,531,328.00        | 1,402,418,900.00        |
| <b>1311</b> | <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>   | <b>152,965,630.00</b>   | <b>17,728,900.00</b>    |
| 131105      | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 152,965,630.00          | 17,728,900.00           |
| <b>2</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>   | <b>1,517,557,979.68</b> | <b>2,009,781,215.89</b> |
| <b>21</b>   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>   | <b>1,517,557,979.68</b> | <b>2,009,781,215.89</b> |
| <b>210</b>  | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                                       | <b>1,429,338,856.95</b> | <b>1,945,416,190.77</b> |
| <b>2101</b> | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>                                     | <b>779,581,927.47</b>   | <b>1,140,784,450.83</b> |
| 210101      | Үндсэн цалин   | 567,004,700.00          | 821,942,681.00          |
| 210102      | Нэмэгдэл   | 142,580,764.47          | 192,299,296.83          |
| 210103      | Унаа хоолны хөнгөлөлт  | 69,996,463.00           | 126,542,473.00          |
| <b>2102</b> | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>                        | <b>89,424,177.60</b>    | <b>126,837,837.28</b>   |
| 210201      | Тэтгэврийн даатгал   | 70,651,129.60           | 99,927,391.45           |
| 210202      | Тэтгэмжийн даатгал   | 8,231,823.00            | 11,459,081.83           |
| 210203      | ҮОМШӨ-ний даатгал  | 6,501,860.00            | 8,899,716.00            |
| 210204      | Ажилгүйдлийн даатгал   | 367,215.00              | 895,067.00              |
| 210205      | Эрүүл мэндийн даатгал  | 3,672,150.00            | 5,656,581.00            |
| <b>2103</b> | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>                             | <b>72,168,699.68</b>    | <b>84,185,399.92</b>    |
| 210301      | Гэрэл, цахилгаан   | 49,549,293.85           | 49,347,379.53           |
| 210302      | Түлш, халаалт  | 13,058,272.53           | 14,236,082.13           |

|             |   |                        |                         |
|-------------|---|------------------------|-------------------------|
| 210303      | Цэвэр, бохир ус   | 9,561,133.30           | 20,601,938.26           |
| <b>2104</b> | <b>Хангамж, бараа материалын зардал</b>                         | <b>10,180,790.00</b>   | <b>13,177,200.00</b>    |
| 210401      | Бичиг хэрэг   | 391,000.00             | 1,904,800.00            |
| 210402      | Тээвэр, шатахуун  | 990,000.00             | 1,962,000.00            |
| 210403      | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр                              | 369,300.00             | 316,800.00              |
| 210405      | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал       | 2,139,750.00           | 1,570,370.00            |
| 210406      | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс                     | 6,290,740.00           | 7,423,230.00            |
| 210408      | Бараа материал акталсны зардал                                  | -                      | -                       |
| <b>2105</b> | <b>Норматив зардал</b>  | -                      | <b>7,848,000.00</b>     |
| 210503      | Нормын хувцас, зөөлөн эдлэл                                     | -                      | 7,848,000.00            |
| 2106        | Эд хогшил, урсгал засварын зардал                               | -                      | 47,482,070.00           |
| 210601      | Багаж хэрэгсэл  | -                      | 16,099,850.00           |
| 210604      | Урсгал засвар   | -                      | 31,382,220.00           |
| <b>2108</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b> | <b>1,211,800.00</b>    | <b>6,244,325.00</b>     |
| 210802      | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох                        | 823,800.00             | -                       |
| 210803      | Даатгалын үйлчилгээний хөлс                                     |                        | 511,000.00              |
| 210804      | Тээврийн хэрэгслийн татвар                                      |                        | 44,500.00               |
| 210806      | Мэдээлэл, технологийн үйлчилгээ                                 | 388,000.00             | 558,000.00              |
| 210807      | Газрын төлбөр   | -                      | 5,130,825.00            |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                          | <b>476,771,462.20</b>  | <b>518,856,907.74</b>   |
| 210901      | Бараа үйлчилгээний бусад зардал                                 | 261,153,323.53         | 281,579,805.27          |
| 210903      | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол                              | 215,618,138.67         | 237,277,102.47          |
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>   | <b>88,219,122.73</b>   | <b>64,365,025.12</b>    |
| <b>2132</b> | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>                                   | <b>23,094,128.00</b>   | <b>30,520,312.00</b>    |
| 213207      | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж             | 22,319,128.00          | 29,077,912.00           |
| 213209      | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал                         | 775,000.00             | 1,442,400.00            |
| <b>2133</b> | <b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>              | <b>65,124,994.73</b>   | <b>33,844,713.12</b>    |
| 213303      | Төвлөрүүлэх шилжүүлэг   | 65,124,994.73          | 33,844,713.12           |
| <b>3</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>                       | <b>(35,553,401.68)</b> | <b>(229,791,927.89)</b> |
| <b>5</b>    | <b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>                                  | <b>(35,553,401.68)</b> | <b>(229,791,927.98)</b> |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Дансны код    | Үзүүлэлт   | Өмнөх он                | Тайлант он              |
|---------------|--|-------------------------|-------------------------|
| <b>1</b>      | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>                                | <b>1,434,040,078.00</b> | <b>1,816,872,780.00</b> |
| <b>12</b>     | <b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>   | <b>73,543,120.00</b>    | <b>243,759,350.00</b>   |
| <b>120</b>    | <b>Нийтлэг татварын бус орлого</b>   | <b>73,543,120.00</b>    | <b>243,759,350.00</b>   |
| <b>120004</b> | <b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>                                      | <b>73,543,120.00</b>    | <b>243,759,350.00</b>   |
| 1200041       | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих                                    | 73,543,120.00           | 243,759,350.00          |
| 120009        | Бусад орлого   | -                       | -                       |
| <b>13</b>     | <b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>   | <b>1,360,496,958.00</b> | <b>1,573,113,430.00</b> |
| <b>1310</b>   | <b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>   | <b>1,207,531,328.00</b> | <b>1,402,418,900.00</b> |
| 131001        | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт  | 1,207,531,328.00        | 1,402,418,900.00        |
| <b>1311</b>   | <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>   | <b>152,965,630.00</b>   | <b>170,694,530.00</b>   |
| 131105        | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 152,965,630.00          | 170,694,530.00          |
| <b>2</b>      | <b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>                                 | <b>1,430,640,378.00</b> | <b>1,750,256,376.00</b> |
| <b>21</b>     | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>   | <b>1,430,640,378.00</b> | <b>1,750,256,376.00</b> |
| <b>210</b>    | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                                       | <b>552,109,917.15</b>   | <b>951,167,851.92</b>   |
| <b>2101</b>   | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>                                     | <b>416,452,227.47</b>   | <b>569,910,266.00</b>   |
| 210101        | Үндсэн цалин   | 277,998,087.84          | 350,582,209.00          |
| 210102        | Нэмэгдэл   | 89,930,951.33           | 140,018,874.00          |
| 210103        | Унаа хоолны хөнгөлөлт  | 28,479,775.00           | 52,741,459.00           |
| 210104        | Урамшуулал   | 20,043,413.30           | 26,567,724.00           |
| <b>2102</b>   | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>                        | <b>52,096,400.00</b>    | <b>140,553,309.00</b>   |
| 210201        | Тэтгэврийн даатгал   | 35,425,700.00           | 117,756,809.00          |
| 210202        | Тэтгэмжийн даатгал   | 4,167,800.00            | 5,699,100.00            |
| 210203        | ҮОМШӨ-ний даатгал  | 3,334,000.00            | 2,849,500.00            |
| 210204        | Ажилгүйдлийн даатгал   | 833,500.00              | 2,849,600.00            |
| 210205        | Эрүүл мэндийн даатгал  | 8,335,400.00            | 11,398,300.00           |
| <b>2103</b>   | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>                             | <b>72,168,699.68</b>    | <b>84,185,399.92</b>    |
| 210301        | Гэрэл, цахилгаан   | 49,549,293.85           | 49,347,379.53           |

|             |   |                       |                       |
|-------------|---|-----------------------|-----------------------|
| 210302      | Түлш, халаалт   | 13,058,272.53         | 14,236,082.13         |
| 210303      | Цэвэр, бохир ус   | 9,561,133.30          | 20,601,938.26         |
| <b>2104</b> | <b>Хангамж, бараа материалын зардал</b>                                     | <b>10,180,790.00</b>  | <b>43,177,200.00</b>  |
| 210401      | Бичиг хэрэг   | 391,000.00            | 1,904,800.00          |
| 210402      | Тээвэр, шатахуун  | 990,000.00            | 1,962,000.00          |
| 210403      | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр  | 369,300.00            | 316,800.00            |
| 210405      | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал                   | 2,139,750.00          | 1,570,370.00          |
| 210406      | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс                                 | 6,290,740.00          | 37,423,230.00         |
| <b>2105</b> | <b>Норматив зардал</b>  | -                     | <b>7,848,000.00</b>   |
| 210503      | Нормын хувцас, зөөлөн эдлэл   | -                     | 7,848,000.00          |
| <b>2106</b> | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>                                    | -                     | <b>104,380,177.00</b> |
| 210601      | Багаж техник хэрэгсэл   | -                     | 15,510,150.00         |
| 210604      | Урсгал засвар   | -                     | 88,870,027.00         |
| <b>2108</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>             | <b>1,211,800.00</b>   | <b>1,113,500.00</b>   |
| 210802      | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох                                    | 823,800.00            | -                     |
| 210803      | Даатгалын үйлчилгээ   | -                     | 511,000.00            |
| 210804      | Тээврийн хэрэгслийн татвар  | -                     | 44,500.00             |
| 210806      | Мэдээлэл, технологийн үйлчилгээ   | 388,000.00            | 558,000.00            |
| <b>212</b>  | <b>ТАТААС</b>   | <b>637,345,708.12</b> | <b>716,994,598.96</b> |
| <b>2121</b> | <b>Төрийн өмчит байгууллагад олгох татаас</b>                               | <b>637,345,708.12</b> | <b>716,994,598.96</b> |
| 212101      | Төрийн өмчит байгууллагад олгох татаас                                      | 637,345,708.12        | 716,994,598.96        |
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>   | <b>241,184,752.73</b> | <b>82,093,925.12</b>  |
| <b>2132</b> | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>   | <b>23,094,128.00</b>  | <b>30,520,312.00</b>  |
| 213207      | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж                         | 22,319,128.00         | 29,077,912.00         |
| 213209      | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал                                     | 775,000.00            | 1,442,400.00          |
| <b>2133</b> | <b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>                          | <b>65,124,994.73</b>  | <b>33,844,713.12</b>  |
| 213303      | Төвлөрүүлэх шилжүүлэг   | 65,124,994.73         | 33,844,713.12         |
| <b>2134</b> | <b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b> | <b>152,965,630.00</b> | <b>17,728,900.00</b>  |
| 213305      | Нэмэлт санхүүжилтийн шилжүүлэг  | 152,965,630.00        | 17,728,900.00         |
| <b>3</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>                     | <b>3,399,700.00</b>   | <b>66,616,404.00</b>  |

|        |  |                       |                        |
|--------|--|-----------------------|------------------------|
| 5      | <b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН<br/>ЗАРДЛЫН ДҮН (5)</b>                               | <b>3,399,700.00</b>   | <b>66,616,404.00</b>   |
| 22     | <b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>  | <b>3,399,700.00</b>   | <b>66,616,404.00</b>   |
| 2200   | <b>Дотоод эх үүсвэрээр</b>   | <b>3,399,700.00</b>   | <b>66,616,404.00</b>   |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан<br>авсан зардал                                  | 3,399,700.00          | 66,616,404.00          |
| 6      | <b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ<br/>АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН<br/>ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b> | <b>(3,399,700.00)</b> | <b>(66,616,404.00)</b> |
| 7      | <b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ<br/>ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>                         | -                     | -                      |
| 8      | <b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ<br/>(8)=(3)+(6)+(7)</b>                               | -                     | -                      |
| 9      | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн<br/>эхний үлдэгдэл</b>                        | -                     | -                      |
| 10     | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн<br/>эцсийн үлдэгдэл</b>                       | -                     | -                      |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Үзүүлэлт   | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн  | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|--|---------------------------------|-----------------------|--------------------|--|
| <b>2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>       | 5,959,596,819.84                | 1,638,744,785.20      | (945,335,032.38)   | 6,653,006,572.66                       |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт       | -                               | -                     | 1,549,995.00       | 1,549,995.00                           |
| <b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>                | 5,959,596,819.84                | 1,638,744,785.20      | (943,785,037.38)   | 6,654,556,567.66                       |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | -                               | (1,549,995.00)        | -                  | (1,549,995.00)                         |
| Тайлант үеийн үр дүн                             | -                               | -                     | (35,553,401.68)    | (35,553,401.68)                        |
| <b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>     | 5,959,596,819.84                | 1,637,194,790.20      | (979,338,439.06)   | 6,617,453,170.98                       |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт       | -                               | -                     | -                  | -                                      |
| <b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>                | 5,959,596,819.84                | 1,637,194,790.20      | (979,338,439.06)   | 6,617,453,170.98                       |
| Тайлант үеийн үр дүн                             | -                               | -                     | (229,791,927.89)   | (229,791,927.89)                       |
| <b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>     | 5,959,596,819.84                | 1,637,194,790.20      | (1,209,130,366.95) | 6,387,661,243.09                       |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Код    | Үзүүлэлт  | Төлөвлөгөө              | Гүйцэтгэл               | Зөрүү            | Хувь          |
|--------|---|-------------------------|-------------------------|------------------|---------------|
| 2      | <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>                  | <b>1,612,418,900.00</b> | <b>1,612,334,555.88</b> | <b>84,344.12</b> | <b>99.99</b>  |
| 21     | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>                                      | <b>1,612,418,900.00</b> | <b>1,612,334,555.88</b> | <b>84,344.12</b> | <b>99.99</b>  |
| 210    | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                    | <b>864,298,100.00</b>   | <b>864,269,744.92</b>   | <b>28,355.08</b> | <b>100.00</b> |
| 2101   | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>                  | <b>569,913,800.00</b>   | <b>569,910,266.00</b>   | <b>3,534.00</b>  | <b>100.00</b> |
| 210101 | Үндсэн цалин  | 355,762,500.00          | 350,582,209.00          | 5,180,291.00     | 98.54         |
| 210102 | Нэмэгдэл  | 164,341,200.00          | 140,018,874.00          | 24,322,326.00    | 85.20         |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт                                     | 18,517,400.00           | 52,741,459.00           | (34,224,059.00)  | 284.82        |
| 210104 | Урамшуулал  | 31,292,700.00           | 26,567,724.00           | 4,724,976.00     | 84.90         |
| 2102   | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>     | <b>140,553,400.00</b>   | <b>140,553,309.00</b>   | <b>91.00</b>     | <b>100.00</b> |
| 210201 | Тэтгэврийн даатгал  | 116,916,600.00          | 117,756,809.00          | (840,209.00)     | 100.72        |
| 210202 | Тэтгэмжийн даатгал  | 5,909,300.00            | 5,699,100.00            | 210,200.00       | 96.44         |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал   | 3,910,200.00            | 2,849,500.00            | 1,060,700.00     | 72.87         |
| 210203 | Ажилгүйдлийн даатгал                                      | 1,999,000.00            | 2,849,600.00            | (850,600.00)     | 142.55        |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал                                     | 11,818,300.00           | 11,398,300.00           | 420,000.00       | 96.45         |
| 2103   | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>          | <b>84,185,400.00</b>    | <b>84,185,399.92</b>    | <b>0.08</b>      | <b>100.00</b> |
| 210301 | Гэрэл, цахилгаан  | 45,786,000.00           | 49,347,379.53           | (3,561,379.53)   | 107.78        |
| 210302 | Түлш, халаалт   | 26,171,200.00           | 14,236,082.13           | 11,935,117.87    | 54.40         |
| 210303 | Цэвэр, бохир ус   | 12,227,600.00           | 20,601,938.26           | (8,374,338.26)   | 168.49        |
| 2104   | <b>Хангамж, бараа материалын зардал</b>                   | <b>13,177,300.00</b>    | <b>13,177,200.00</b>    | <b>100.00</b>    | <b>100.00</b> |
| 210401 | Бичиг хэрэг   | 1,490,500.00            | 1,904,800.00            | (414,300.00)     | 127.80        |
| 210402 | Тээвэр, шатахуун  | 1,962,000.00            | 1,962,000.00            | -                | 100.00        |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр                        | 338,600.00              | 316,800.00              | 21,800.00        | 93.56         |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,410,500.00            | 1,570,370.00            | 840,130.00       | 65.15         |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс               | 6,975,700.00            | 7,423,230.00            | (447,530.00)     | 106.42        |

|               |   |                         |                         |                        |               |
|---------------|---|-------------------------|-------------------------|------------------------|---------------|
| <b>2105</b>   | <b>Нормативт зардал</b>   | <b>7,848,000.00</b>     | <b>7,848,000.00</b>     | <b>-</b>               | <b>100.00</b> |
| 210503        | Нормын хувцас зөөлөө эдлэл                                      | 7,848,000.00            | 7,848,000.00            | -                      | 100.00        |
| <b>2106</b>   | <b>Эд хогшил худалдан авах</b>                                  | <b>47,502,000.00</b>    | <b>47,482,070.00</b>    | <b>19,930.00</b>       | <b>99.96</b>  |
| 210601        | Багаж, техник, хэрэгсэл   | 9,810,000.00            | 16,099,850.000          | (6,289,850.00)         | 164.12        |
| 210604        | Урсгал засвар   | 37,692,000.00           | 31,382,220.00           | 6,309,780.00           | 83.26         |
| <b>2108</b>   | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b> | <b>1,118,200.00</b>     | <b>1,113,500.00</b>     | <b>4,700.00</b>        | <b>99.58</b>  |
| 210803        | Даатгалын үйлчилгээ   | 525,000.00              | 511,000.00              | 14,000.00              | 97.33         |
| 210804        | Тээврийн хэрэгслийн татвар                                      | -                       | 44,500.00               | (44,500.00)            |               |
| 210805        | Тээврийн хэрэгслийн оношилгоо                                   | 155,900.00              | -                       | 155,900.00             |               |
| 210806        | Мэдээлэл, технологийн зардал                                    | 308,100.00              | 558,000.00              | (249,900.00)           | 181.11        |
| 210809        | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж              | 129,200.00              | -                       | 129,200.00             |               |
|               | <b>ТАТААС</b>   | <b>717,550,000.00</b>   | <b>717,544,498.96</b>   | <b>5,501.04</b>        | <b>100.00</b> |
|               | <b>Төрийн өмчит байгууллагад олгох татаас</b>                   | <b>717,550,000.00</b>   | <b>717,544,498.96</b>   | <b>5,501.04</b>        | <b>100.00</b> |
|               | Төрийн өмчит байгууллагад олгох татаас                          | 717,550,000.00          | 717,544,498.96          | 5,501.04               | 100.00        |
| <b>213</b>    | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>   | <b>30,570,800.00</b>    | <b>30,520,312.00</b>    | <b>50,488.00</b>       | <b>99.83</b>  |
| <b>2132</b>   | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>                                   | <b>30,570,800.00</b>    | <b>30,520,312.00</b>    | <b>50,488.00</b>       | <b>99.83</b>  |
| 213207        | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж             | 29,128,400.00           | 29,077,912.00           | 50,488.00              | 99.83         |
| 213209        | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал                         | 1,442,400.00            | 1,442,400.00            | -                      | 100.00        |
|               | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>                           | <b>1,612,418,900.00</b> | <b>1,646,178,250.00</b> | <b>(33,759,350.00)</b> | <b>102.09</b> |
| <b>1310</b>   | <b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>                                  | <b>1,402,418,900.00</b> | <b>1,402,418,900.00</b> | <b>-</b>               | <b>100.00</b> |
| <b>131001</b> | <b>Улсын төсвөөс санхүүжих</b>                                  | <b>1,402,418,900.00</b> | <b>1,402,418,900.00</b> | <b>-</b>               | <b>100.00</b> |
| <b>120004</b> | <b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>                    | <b>210,000,000.00</b>   | <b>243,759,350.00</b>   | <b>(33,759,350.00)</b> | <b>116.08</b> |

|             |   |                |                |                 |               |
|-------------|---|----------------|----------------|-----------------|---------------|
| 120004<br>1 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 210,000,000.00 | 243,759,350.00 | (33,759,350.00) | 116.08        |
| <b>61</b>   | <b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>                   | <b>1</b>       | <b>1</b>       | <b>-</b>        | <b>100.00</b> |
| 610001      | Төсвийн байгууллага                       | 1              | 1              | -               | 100.00        |
|             | <b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>                    | <b>30</b>      | <b>30</b>      | <b>-</b>        | <b>100.00</b> |
| 650001      | Удирдах ажилтан                           | 1              | 1              | -               | 100.00        |
| 650002      | Гүйцэтгэх ажилтан                         | 8              | 8              | -               | 100.00        |
| 650003      | Үйлчлэх ажилтан                           | 21             | 21             | -               | 100.00        |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Код    | Үзүүлэлт   | Төлөвлөгөө | Гүйцэтгэл             |
|--------|--|------------|-----------------------|
| 2      | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН  | -          | 152,964,611.00        |
| 21     | УРСГАЛ ЗАРДАЛ  | -          | 152,964,611.00        |
| 210    | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ  | -          | 152,964,611.00        |
| 2104   | Хангамж, бараа материалын зардал   | -          | 30,000,000.00         |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс                                  | -          | 30,000,000.00         |
| 210604 | Урсгал засвар  | -          | 122,964,611.00        |
|        | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>  | -          | <b>170,694,530.00</b> |
|        | <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>   | -          | <b>170,694,530.00</b> |
|        | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | -          | 170,694,530.00        |

### 3. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ:

Аудитаар нийт 1,728.3 сая төгрөгийн зөрчил илэрснээс 64.2 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 1,664.1 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

3.1.Аудитаар нийт 117.8 сая төгрөгийн зөрчил илэрсэнд 64.2 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 53.5 сая төгрөгийн зөрчлийг зөрчлийг давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн.

#### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга  | Нийт зөрчил |                  | Үүнээс        |          |                 |                 |          |                 |                                      |                     |   |          |
|---|-------------|------------------|---------------|----------|-----------------|-----------------|----------|-----------------|--------------------------------------|---------------------|---|----------|
|   |             |                  | Төлбөрийн акт |          | Албан шаардлага |                 | Зөвлөмж  |                 | Хариуцлага тооцуулах албан шаардлага |                     | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал |          |
|   | Тоо         | Дүн              | Тоо           | Дүн      | Тоо             | Дүн             | Тоо      | Дүн             | Тоо                                  | Албан тушаалтны тоо | Тоо   | Дүн      |
| Тайлант хугацаанд 17,728.9 мянган төгрөгийн дансны авлагын үлдэгдлийг аж ахуйн нэгж, байгууллагатай тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, өмнөх онуудад үүссэн 46,514.7 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй байна.   | 1           | 64,243.6         | -             | -        | 1               | 64,243.6        | -        | -               | -                                    | -                   | -   | -        |
| Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 заасан бүрэлдэхүүний дагуу гаргаагүй байна.   | 1           | -                | -             | -        | -               | -               | 1        | -               | -                                    | -                   | -   | -        |
| Хяналтын камер худалдан авах 4,484.0 мянган төгрөг, А хэмжээтэй бор цаас 9,486.4 мянган төгрөг, Даавуу, хөвөн, материал авах 15,790.0 мянган төгрөг, Босоо халуун хөшиг, халуун хөшиг 5,100.0 мянган төгрөг, Бор цаас, дрилл, хайрцаг, өрөм дорцов 9,150.0 мянган төгрөг, Бор цаас, утас, кабел, далдлагч 9,538.5 мянган төгрөг буюу нийт 53,548.9 мянган төгрөгийн түүхий эд материалыг цахим дэлгүүрээс тус тус худалдан авалт хийгээгүй. | 1           | 53,548.9         | -             | -        | -               | -               | 1        | 53,548.9        | -                                    | -                   | -   | -        |
| <b>Дүн</b>  | <b>3</b>    | <b>117,792.5</b> | <b>-</b>      | <b>-</b> | <b>1</b>        | <b>64,243.6</b> | <b>2</b> | <b>53,548.9</b> | <b>-</b>                             | <b>-</b>            | <b>-</b>  | <b>-</b> |

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

3.2. Нийцлийн аудиттай холбоотой нийт 1,610.5 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 1,610.5 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга   | Нийт зөрчил |                    | Үүнээс          |          |          |                    |
|--|-------------|--------------------|-----------------|----------|----------|--------------------|
|  |             |                    | Албан шаардлага |          | Зөвлөмж  |                    |
|  | Тоо         | Дүн                | Тоо             | Дүн      | Тоо      | Дүн                |
| <b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>  |             |                    |                 |          |          |                    |
| Шилэн дансны цахим хуудсанд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 1,396,928.7 мянган төгрөгийн 30 гүйлгээг мэдээлээгүй, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 17,728.9 мянган төгрөгийн 1 гүйлгээг мэдээлээгүй байна.   | 1           | 1,414,657.6        | -               | -        | 1        | 1,414,657.6        |
| <b>Дүн</b>   | <b>1</b>    | <b>1,414,657.6</b> | <b>-</b>        | <b>-</b> | <b>1</b> | <b>1,414,657.6</b> |
| <b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>  |             |                    |                 |          |          |                    |
| Тайланд онд 42,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй харуул хамгаалалтын үйлчилгээний харьцуулалтын тендерийг цахимаар зохион байгуулаагүй.   | 1           | 42,000.0           | -               | -        | 1        | 42,000.0           |
| Мэдээллийн аюулгүй байдлыг иж бүрэн /холбогдох хуулийг/ хэрэгжүүлж ажиллаагүй. Тус байгууллагын мэдээллийг дамжуулж байгаа санхүүгийн болон байгууллагын ажиллагсад албаны цахим хаяг ашиглахгүй байна. Улмаар мэдээллийн аюулгүй байдлыг хэрхэн хангаж ажиллаж байгаа тодорхой бус байна. | 1           | -                  | -               | -        | 1        | -                  |
| 153,862.1 мянган төгрөгийн засварын ажилд мэргэшсэн төсөвчний баталгаажуулсан төсөв байхгүй, үнэлгээний хорооны гишүүд гэрчилгээгүй, хурлын тэмдэглэлд гарын үсэг зураагүй.  | 1           | 153,862.1          | -               | -        | 1        | 153,862.1          |
| <b>Дүн</b>   | <b>3</b>    | <b>195,862.1</b>   | <b>-</b>        | <b>-</b> | <b>3</b> | <b>195,862.1</b>   |
| <b>Нийт дүн</b>  | <b>4</b>    | <b>1,610,519.7</b> | <b>-</b>        | <b>-</b> | <b>4</b> | <b>1,610,519.7</b> |